



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/59/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын хэлтсийн ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 325093 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:  
Мэдээлэл Аудит ХХК-ийн захирал: Д.Товуудорж  
Утас: 9904-9511 Цахим хаяг: [medeelelaudit@gmail.com](mailto:medeelelaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 508

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 413.4 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 4,877.2 сая төгрөгийн орлого олж, 4,475.9 сая төгрөгийн зардал гаргаж 362.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 1/1380 дугаар албан бичгийг үндэслэн 17,833.7 сая төгрөгийн газрыг данс бүртгэлд бүртгэсэн байна.

1426050417

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 27 дугаар тогтоолоор байгууллагын "Стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичиг"-ийг, 32 дугаар тогтоолоор "Арга хэмжээ зохион байгуулах журам"-ыг шинэчлэн баталсан байна. Тус журмын хүрээнд 2026 оны тоглолтын худалдан авах ажиллагааг зохион байгуулснаар 3 байгууллагаас 652.6 сая төгрөгийн орлого урьдчилж орсон байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Байгууллага жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 99.5 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Хөрөнгө</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	134,422,842.74	723,091,267.56
1.1.2	Дансны авлага	28,354,000.00	159,521,682.44
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	2,583,621.64	
1.1.4	Бусад авлага	87,900,079.47	106,948,301.47
1.1.6	Бараа материал	81,808,366.94	190,890,599.56
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,347,160.00	
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>341,416,070.79</b>	<b>1,180,451,851.03</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,822,832,673.80	21,701,753,402.49
1.2.2	Биет бус хөрөнгө		11,976,634.11
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,822,832,673.80</b>	<b>21,713,730,036.60</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,164,248,744.59</b>	<b>22,894,181,887.63</b>
2.1.1.1	Дансны өглөг	135,553,326.11	88,627,143.32
2.1.1.3	Татварын өр	58,296,057.34	45,552,772.74
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	59,000,000.00	652,561,111.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>252,849,383.45</b>	<b>786,741,027.06</b>
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>252,849,383.45</b>	<b>786,741,027.06</b>
<b>2.3</b>	<b>Өмч</b>	<b>1,920,022,542.00</b>	<b>1,920,022,542.00</b>
2.3.1	төрийн	1,920,022,542.00	1,920,022,542.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	175,813,722.00	175,813,722.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		17,833,728,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,815,563,097.14	2,177,876,596.57
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,911,399,361.14</b>	<b>22,107,440,860.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,164,248,744.59</b>	<b>22,894,181,887.63</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,453,818,383.75	4,453,020,711.31
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,257,953,091.39	0.00
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>2,195,865,292.36</b>	<b>4,453,020,711.31</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	50,495.30	0.00
8	Бусад орлого	0.00	432,801,562.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	372,170,437.05	1,750,311,472.54
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,021,543,181.71	2,725,658,335.75
12	Бусад зардал	0.00	8,098,012.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,878.87	253.38
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-999,680,838.12	1,715,599.36
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-197,476,790.35</b>	<b>403,470,305.93</b>
19	Орлогын татварын зардал	0.00	41,156,806.50
<b>20</b>	<b>Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-197,476,790.35</b>	<b>362,313,499.43</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-197,476,790.35</b>	<b>362,313,499.43</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>24</b>	<b>Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>-197,476,790.35</b>	<b>362,313,499.43</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн бусад хэсэг	НИЙТ ДҮН
<b>2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл</b>	2,073,416,264.00	1,975,666,723.28		4,049,082,987.28
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	37,373,164.21		37,373,164.21
Залруулсан үлдэгдэл	2,073,416,264.00	2,013,039,887.49		4,086,456,151.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-197,476,790.35		-197,476,790.35
Бусад дэлгэрэнгүй орлого	0	-		-
Өмчид гарсан өөрчлөлт	22,420,000.00			22,420,000.00
Зарласан ногдол ашиг	0	-		-
Дахин үнэлгээний нэмэгдэл	0	-		-
<b>2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	2,095,836,264.00	1,815,563,097.14		3,911,399,361.14
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0			
Залруулсан үлдэгдэл	0			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	362,313,499.43		362,313,499.43
Бусад дэлгэрэнгүй орлого	0	-		-
Өмчид гарсан өөрчлөлт	0	-	17,833,728,000.00	17,833,728,000.00
Зарласан ногдол ашиг	0	-		-
Дахин үнэлгээний нэмэгдэл	0	-		-
<b>2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	2,095,836,264.00	362,313,499.43	17,833,728,000.00	22,107,440,860.57

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>3,934,947,308.66</b>	<b>6,414,529,418.07</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,386,955,487.72	5,304,445,633.45
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	617,882,552.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	930,109,268.94	1,110,083,784.62
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,876,385,393.61</b>	<b>5,362,625,519.58</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	479,501,948.09	1,247,533,477.74
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	134,386,369.01	333,045,176.19
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,526,830,166.22	260,718,008.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	174,740,340.68	235,469,279.17
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	38,934,632.37	16,297,601.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	330,514,017.11	613,629,036.35
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	191,477,920.13	2,655,932,941.13
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,058,561,915.05</b>	<b>1,051,903,898.49</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>24,760,452.00</b>	<b>3,500,000.00</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	3,500,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	24,760,452.00	0.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,584,856,272.00</b>	<b>466,744,445.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,584,856,272.00	458,494,445.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	8,250,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-1,560,095,820.00</b>	<b>-463,244,445.00</b>
<b>3</b>	<b>Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>24,000,000.00</b>	<b>0.00</b>

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	24,000,000.00	0.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>91,380,079.47</b>	<b>0.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,650,000.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	87,730,079.47	0.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-67,380,079.47</b>	<b>0.00</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>1,878.87</b>	<b>8,971.33</b>
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-568,912,105.55	588,668,424.82
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>703,334,948.29</b>	<b>134,422,842.74</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>134,422,842.74</b>	<b>723,091,267.56</b>

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 573,262.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 435,919.8 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 135,135.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Төлөвлөгөөнд тусгаагүй 2,207.4 мянган төгрөгийг ТУЗ-ын дарга, гишүүдэд олгосон	1	2,207.4	1	2,207.4											
2	Байгууллагаас авах 87,730.1 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй	1	87,730.1			1	87,730.1									
3	Хөлсөөр ажиллах цаглабар хугацаатай гэрээг дүгнэсэн акт хийж 4,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.	1	4,500.0			1	4,500.0									
4	Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээний 196,504.8 мянган төгрөгийг шууд худалдан авалтанд зориулж хуваан гүйцэтгүүлсэн	1	196,504.8			1	196,504.8									
5	Үйл ажиллагааны чиглэл өөр өөр газраас ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 18,000.0 мянган төгрөгийн үйлчилгээнд хөрөнгө зарцуулсан	1	18,000.0			1	18,000.0									
6	Мөнгөн хөрөнгийн зарлагын журналыг цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 129,184.9 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	129,184.9			1	129,184.9									
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>438,127.2</b>	<b>1</b>	<b>2,207.4</b>	<b>5</b>	<b>435,919.8</b>									

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
<i>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч тендерийн өгөгдлийн хүснэгтийн шалгуур хангаагүй байгууллага шалгаруулсан	1	135,135.0					1	135,135.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>135,135.0</b>					<b>1</b>	<b>135,135.0</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 05 дугаар сарын 15

№ 101/13710508

Улаанбаатар хот

НААТ-2026/059/НА-СТН-ОНӨЧТ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд төлөвлөгөөнд тусгаагүй 2,207,414.00 (хоёр сая хоёр зуун долоон мянга дөрвөн зуун арван дөрөв) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12-т "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК төлөвлөгөөнд тусгаагдаагүй зардал гаргасан 2,207,414.30 (Хоёр сая хоёр зуун долоон мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийг Гүйцэтгэх захирал /Д.Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Сэлэнгэ/ нараар нөхөн төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын IBAN440090100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Сэлэнгэ/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ТОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110111



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 295 /13910508

Улаанбаатар хот

НААТ- 2026 /059/НА-СОА - ОМӨЧТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагаас авах 87,730,081.50 (наян долоон сая долоон зуун гучин мянга наян нэгэн төгрөг тавин мөнгө) төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Лхагвадулам/, Ерөнхий нягтлан бодогч /Ц. Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 276/15710508

Улаанбаатар хот

НТАА-2026/059/11А-СНН-04041

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээ дуусах болон гэрээний хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй /1 сарын өмнө/ байхад гэрээг дүгнэж 4,500,000.0 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн төлбөрийг 100.0 хувь олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна..

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Хэрэгжиж дуусаагүй ажлыг урьдчилан дүгнэж, санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц. Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 277/13710508

Улаанбаатар хот

НААТ-2026/059/НА-СТА-ОНӨЧТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ижил төрлийн бараа, ажил үйлчилгээний 196,504,820.0 (нэг зуун ерэн зургаан сая таван зуун дөрвөн мянга найман зуун хорь) төгрөгийн худалдан авалтад худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц. Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 298 /13710508

Улаанбаатар хот

МНТ-2026/059/НН-СМН-ОНӨЧГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээн дэх ажил нь тухайн байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан үйл ажиллагааны чиглэлээс зөрүүтэй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 18,000,000.00 (арван найман сая) төгрөгийн худалдан авалт хийж хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.4-д "Компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Үйл ажиллагааны чиглэл зөрүүтэй байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй үйлчилгээг худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц. Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090451



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 279 / 13910508

Улаанбаатар хот

ИММ-2026 / 059 / ИМ-СМ - 04041

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, 129,184,909.4 (Нэг зуун хорин есөн сая нэг зуун наян дөрвөн мянга есөн зуун есөн төгрөг дөчин мөнгө) төгрөгийн ажил гүйлгээг цахим баримтаас зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-; "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Цахим төлбөрийн баримтаас зөрүүтэй ажил гүйлгээг хийж, бүртгэл хөтөлсөн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирал /Д. Лхагвадулам/, ерөнхий нягтлан бодогч /Ц. Сэлэнгэ/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ  
Д.ОТГОНБАЯР  
Д.ТОВУУДОРЖ